

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн  
тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/53/СТА-ТӨҮГ

**Агуулга**

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан .....	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
	2.11. Шилэн дансны мэдээлэл .....	9
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
3	Менежментийн захидал .....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	12
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
	4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	14
	4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
	4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.03.15 № 06/466  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Багануурын дулааны станц ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайланг хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Багануурын дулааны станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Ганбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Тэд-Аудит” ХХК-ийн аудитор Г.Эрдэнэчимэг, П.Ренцэнмядаг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газар болон Тэд-Аудит ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 1/78 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Багануурын дулааны станц ТӨХК нь “Хэрэглэгчээ дээдэлж, хүний хөгжлийн дэвшилтэт технологид түшиглэн үр ашигтай үйлдвэрлэл явуулж, стандартын шаардлага хангасан дулааны эрчим хүчээр тасралэгүй, найдвартай хангах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Тус компани нь дулааны эрчим хүч үйлдвэрлэж, Багануур дүүргийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг дулаанаар хангах, түгээхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллаж байна.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2018 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, Зорилтот түвшин, төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 671 тоот тогтоолоор баталжээ. Үүнд:

Дулааны эрчим хүчний талаар:

Тайлант жилд 156.9 мянган Г/кал дулааны эрчим хүч үйлдвэрлэх, 5,252.0 сая төгрөгийн борлуулалтын орлогын төлөвлөгөөтэй, үйл ажиллагааны зардалд 6,411.9 сая төгрөг төлөвлөж, тайлант жилд ашиг алдагдлын хэмжээг 87.9 сая төгрөгөөс хэтрүүлэхгүй байхаар зорилтот түвшинг баталжээ.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Татварын багц хууль

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Веница” програм хангамж ашиглаж байна.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Багануурын дулааны станц ТӨХК-ийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг

баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт орлогын дүнгээс 1 хувиар сонгов.

2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь АОУС 320-ын дагуу тодорхойлсонтой холбоотой юм.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2018 оны нийт орлого 6,130.1 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 61.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь байгууллагын хамрах хүрээ хязгаарлагдмал, борлуулалтын орлогын хэмжээ бага тул гарч болох эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэж зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулан баталгаажуулсан.

### 2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	9.3	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	



3	Албан шаардлага өгсөн	0	0.00
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00
	Дүн	3	9.3

## 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус компанийн үйл ажиллагааг дэмжиж Эрчим хүчний яам болон Эрчим хүчний зохицуулах хорооноос 2016-2018 онуудад зардал санхүүжилтийн дэмжлэг туслалцаа үзүүлж, хэрэглээний нүүрсний үнэ, цахилгааны тарифыг шат шатлалаар бууруулах, борлуулалтын дулааны тарифыг нэмэгдүүлж өгч байгаагаас зардал, алдагдал буурсан хэдий ч, тус бууралтын хэмжээгээр тухайн жилийн хуримтлагдсан өр буурч байгаа ч тус компанийн өмнөх жилүүдэд хуримтлагдсан өрийн тооцоо сөргөөр нөлөөлж, энэ нь мөнгөн хөрөнгийн урсгал дутагдалтай байгаа байдалд дүн шинжилгээ хийж горим хэрэгжүүлнэ.

## 2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

А. Борлуулалтын орлогын талаар:

Тайлант хугацаанд 5,252.0 сая төгрөгийн борлуулалтын орлогын төлөвлөгөөтэй ажиллан 4,998.4 сая төгрөгийн орлого олж, төлөвлөгөө 253.6 сая төгрөгөөр тасарч борлуулатын орлого 95.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Багануурын уурхай хэрэглээгээ хязгаарласнаар тус компани 6-9 сард тэг зогсолт хийсэн нь орлого оруулахад нөлөөлжээ.

Б. Зардлын талаар:

Үйл ажиллагааны зардалд 6,455.5 сая төгрөг төлөвлөснөөс 6,302.5 сая төгрөгийг зарцуулж, 153.0 сая төгрөгөөр хэмнэжээ. Энэ нь ажиллагсадын цалин, шимтгэлийн зардал зуны саруудад сул зогссоноос хэмнэгдсэн, цахилгааны зардлыг 2018 онд Эрчим хүчний зохицуулах хорооны 192 дугаар тогтоолоор 55.0 хувиар бууруулсантай холбоотой байна.

В. Ашиг алдагдлын талаар:

Тайлант жилд 6,264.8 сая төгрөгийн үйл ажиллагааны, 37.2 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардалтай, 4,998.4 сая төгрөгийн борлуулалтын орлого, 131.8 сая төгрөгийн үйл ажиллагааны бус орлого олж, Улсын төсвөөс 1,000.0 сая төгрөгийн санхүүжилт авснаар 172.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Алдагдлыг төлөвлөсөн хэмжээнээс 84.4 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ.

## Г. Дахин үнэлгээний талаар

Мөн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний үлдэгдэл 697.8 сая төгрөг байсан бөгөөд тайлант жилд 1954.5 сая төгрөгөөр, газрын эрхийн үнэлгээ 1021.7 сая төгрөгөөр тус нэмэгдэж санхүүгийн тайланд бүртгэгдсэн болно.

### 2.11. Шилэн дансны мэдээлэл

Багануурын дулааны станц ТӨХК-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус компанийн байранд олон нийтэд ил тод харагдахаар байрлуулсан мэдээллийн самбар байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 1.1, 5.7, 5.8 дахь заалтуудыг зөрчиж байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 87.1 хувийн биелэлттэй байгаа бөгөөд энэ нь “Эйч Зэт Эйч” ХХК-ийн болон айл өрхөөс авах дулааны авлагын нийт 14.3 сая төгрөгийн эзэн холбогдогчийг тогтоохоор шүүхэд хандсан тул эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Багануурын дулааны станц ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Дотоод аудиттай холбоотой асуудал

##### 3.1.1 Илрүүлэлт:

Тус компани дотоод аудит хариуцсан орон тооны албан тушаалтантай бөгөөд тайлант жилд хийсэн ажлын тайлангаас харахад нэлээд ажлуудыг хийж байгаа ч дотоод аудитын тайлангийн бүтэц эмх замбараагүй, төлөвлөлтийн шатанд эрсдэл тодорхойлж шалгах асуудал бүрт төлөвлөгөө хөтөлбөр боловсруулж батлуулж ажиллагаагүй, бүтэц зохион байгуулалтын хувьд хараат зарчмаар ажиллаж байгаа нь Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон Улсын стандарт (ДАМПОУС) болон Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 2.1, 3.1 дэх заалтуудыг тус тус зөрчиж байна.

Энэ нь (Холбогдох батламж мэдэгдэл) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон Улсын стандарт (ДАМПОУС) болон Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм” тус тус зөрчсөн байна.

##### 3.1.2 Эрсдэл:

Дотоод аудитын стандарт, дүрэм журам зөрчсөн байх

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон Улсын стандарт (ДАМПОУС) болон Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод

аудитын дүрэм"-ийг үндэслэн байгууллагын онцлогт уялдуулан дүрэм журмыг боловсруулж батлуулан мөрдөж ажиллах

#### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

### **3.2 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчинтой холбоотой асуудал**

#### **3.2.1 Илрүүлэлт:**

Шилэн дансны хэрэгжилтийг шалгахад тайлант жилд өмнөө тавьсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авалт түүний гүйцэтгэл, зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг цахим хуудсаар мэдээлж байгаа боловч компанийн байранд олон нийтэд ил тод харагдахаар байрлуулсан мэдээллийн самбар байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 1.1, 5.7, 5.8 дахь заалтуудыг зөрчиж байна

#### **3.2.2 Эрсдэл:**

Шилэн дансанд тухайн жилийн төсөв төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөө тайланг бүрэн байршуулаагүй байх

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны хууль хэрэгжүүлж ажиллах

#### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

### **3.3 Балансын данстай холбоотой асуудалтай холбоотой асуудал**

#### **3.3.1 Илрүүлэлт:**

Тайлант жилд 9.3 сая төгрөгийн өглөгийг 5 аж ахуйн нэгж байгууллагатай тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

#### **3.3.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайланд тусгасан өр төлбөрийг харилцагч байгууллагаар тооцоо нийлж баталгаажуулаагүй байх

#### **3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Өр, авлагын үлдэгдлийн тооцоог байгууллага нэг бүрээр гаргаж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулж зөв дүнгээр тайланд тусгаж, НББОУС 1-ийг мөрдөж ажиллах

#### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4 Аудит хийсэн санхүүгийн тайлан****4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	20,560,282.88	1,590,323.50
1.1.2	Дансны авлага	277,155,287.28	176,801,948.66
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага	50,374,093.13	43,229,056.89
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	188,285,112.26	189,324,487.89
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>536,374,775.55</b>	<b>410,945,816.94</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	10,123,760,826.05	11,521,771,525.10
1.2.2	Биет бус хөрөнгө		1,021,721,600.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>10,123,760,826.05</b>	<b>12,543,493,125.10</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>10,660,135,601.60</b>	<b>12,954,438,942.04</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	2,310,701,387.89	1,398,997,372.62
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	207,441,134.00	450,488,154.11
2.1.1.4	НДШ–ийн өглөг	21,152,701.66	118,652,691.18
2.1.1.5	Богино хугацаат зээл	300,000,000.00	400,000,000.00
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		1,067,423.78
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		

2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	54,324,800.00	14,456,359.04
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,893,620,023.55</b>	<b>2,383,662,000.73</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	16,937,636.18	17,350,850.65
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>16,937,636.18</b>	<b>17,350,850.65</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>2,910,557,659.73</b>	<b>2,401,012,851.38</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	6,291,517,841.35	6,291,517,841.35
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	697,879,621.79	2,652,391,027.32
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	7,579,468,562.12	8,601,190,162.12
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-6,819,288,083.39	-6,991,672,940.13
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>7,749,577,941.87</b>	<b>10,553,426,090.66</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>10,660,135,601.60</b>	<b>12,954,438,942.04</b>

**4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	4,836,420,142.96	4,998,420,779.59
2	Борлуулалтын өртөг	5,656,915,740.29	5,919,226,023.77
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>-820,495,597.33</b>	<b>-920,805,244.18</b>
4	Түрээсийн орлого	4,243,200.00	4,066,400.00
5	Хүүгийн орлого	779,893.50	658,503.16
8	Бусад орлого	1,233,738,913.21	1,127,031,139.08
10	Ерөнхий ба удирдлагын зардал	220,271,903.23	277,172,919.96
11	Санхүүгийн зардал	78,788,251.40	68,482,931.21
<b>17</b>	<b>Бусад ашиг ( алдагдал)</b>	<b>-127,406,275.02</b>	<b>-37,200,738.84</b>
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-8,200,020.27</b>	<b>-171,905,791.95</b>
<b>19</b>	<b>Орлогын татварын зардал</b>	<b>14,618,541.39</b>	<b>479,064.79</b>
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-22,818,561.66</b>	<b>-172,384,856.74</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>-22,818,561.66</b>	<b>-172,384,856.74</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>		
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

**4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,291,517,841.35	697,879,621.79	6,643,225,708.00	-6,796,469,521.73	6,836,153,649.53
3	Залруулсан үлдэгдэл	6,291,517,841.35	697,879,621.79	6,643,225,708.00	-6,796,469,521.73	6,836,153,649.53
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				-22,818,561.66	-22,818,561.66
6	Өмчид гарсан өөрчлөлт				936,242,854.00	936,242,854.00
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	6,291,517,841.35	697,879,621.79	7,579,468,562.00	-6,819,288,083.39	7,749,577,941.87
11	Залруулсан үлдэгдэл	6,291,517,841.35	697,879,621.79	7,579,468,562.00	-6,819,288,083.39	7,749,577,941.87
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-172,384,856.74	-172,384,856.74
14	Өмчид гарсан өөрчлөлт			1,021,721,600.00		1,021,721,600.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		1,954,511,405.53			1,954,511,405.53
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	6,291,517,841.35	2,652,391,027.32	8,601,190,162.00	-6,991,672,940.13	10,553,426,090.66



**4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>5,022,685,574.03</b>	<b>5,057,011,540.25</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,674,795,275.69	3,747,444,138.46
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	17,855,427.00	14,711,463.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,100,000,000.00	1,100,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	270,034,871.34	194,855,938.79
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>4,583,992,875.38</b>	<b>4,721,220,822.46</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,595,810,508.10	1,779,132,180.89
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	403,514,592.00	439,868,789.74
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	249,552,175.82	271,142,159.95
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,115,405,429.07	994,364,746.09
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	239,144,075.98	361,852,264.79
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	57,578,887.76	60,487,113.02
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	456,432,985.00	389,387,101.66
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	4,526,716.15	6,475,093.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	462,027,505.50	418,511,373.32
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>438,692,698.65</b>	<b>335,790,717.79</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>779,893.50</b>	<b>658,503.16</b>
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	779,893.50	658,503.16
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-430,073,004.00</b>	<b>455,419,180.33</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-430,073,004.00	455,419,180.33
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-429,293,110.50</b>	<b>454,760,677.17</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>350,000,000.00</b>	<b>400,000,000.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	350,000,000.00	400,000,000.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-350,000,000.00</b>	<b>300,000,000.00</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-350,000,000.00	300,000,000.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>100,000,000.00</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>9,399,588.15</b>	<b>18,969,959.38</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>11,160,694.73</b>	<b>20,560,282.88</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>20,560,282.88</b>	<b>1,590,323.50</b>

**5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Ажлын баримтын нэр:</b>	<i>Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл</i>
<b>Ажлын баримтын дугаар:</b>	<i>B501</i>
<b>Аудитын код:</b>	<b>САГ-2019/53/СТА-ТӨҮГ</b>
<b>Аудитын нэр:</b>	<b>Багануурын дулааны станц ТӨХК</b>

(сая. төгрөгөөр)

№	Аудитын чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>9</b>	<b>10</b>
1	Дотоод аудитын талаар	1	Тус компани дотоод аудит хариуцсан орон тооны албан тушаалтантай бөгөөд тайлант жилд хийсэн ажлын тайлангаас харахад нэлээд ажлуудыг хийж байгаа ч дотоод аудитын тайлангийн бүтэц эмх замбараагүй, төлөвлөлтийн шатанд эрсдэл тодорхойлж шалгах асуудал бүрт төлөвлөгөө хөтөлбөр боловсруулж батлуулж ажиллагаагүй, бүтэц зохион байгуулалтын хувьд хараат зарчмаар ажиллаж байгаа нь Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон Улсын стандарт (ДАМПОУС) болон Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 2.1, 3.1 дэх заалтуудыг тус тус зөрчиж байна.	0.0	Зөвлөмж өгсөн	3/11/2019	A/01	Гүйцэтгэх захирал, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга	Н.Ганбаатар, Ц.Энхцэцэг
2	Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчны талаар	1	Шилэн дансны хэрэгжилтийг шалгахад тайлант жилд өмнөө тавьсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авалт түүний гүйцэтгэл, зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг цахим хуудсаар мэдээлж байгаа боловч компанийн байранд олон нийтэд ил тод харагдахаар байрлуулсан мэдээллийн самбар байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 1.1, 5.7, 5.8 дахь заалтуудыг зөрчиж байна	0.0	Зөвлөмж өгсөн	3/11/2019	A/02	Гүйцэтгэх захирал, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга	Н.Ганбаатар, Ц.Энхцэцэг
3	Балансын данстай холбоотой асуудлаар	1	Тайлант жилд 9.3 сая төгрөгийн 5 аж ахуйн нэгж байгууллагатай тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.	9.3	Зөвлөмж өгсөн	3/11/2019	A/03	Гүйцэтгэх захирал, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга	Н.Ганбаатар, Ц.Энхцэцэг



